

## ТАНИЛЦУУЛГА

“Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшид  
мэргэжлийн зэрэг олгох, хасах журам”

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын багш нарын мэдлэг чадвар, мэргэшил аргазүйн чадавхийг дээшлүүлэх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх чухал асуудлын нэг нь багшид мэргэжлийн зэрэг олгох, багшийн ажлын үр дүнг урамшуулан дэмжих явдал юм.

Чадамжид суурилсан сургалтын онцлог, аж үйлдвэрийн IV, V хувьсгал, дижиталчлал, ногоон боловсрол, техник технологийн дэвшилтэй уялдан, мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын багшийг тасралтгүй хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын багш нарын улсын анхдугаар зөвлөгөөний үеэр багшийн мэргэжлийн зэргийн шалгуурыг ажлын үр дүнтэй холбох, хугацааг уян хатан болгох талаар олон санал ирсэн, түүнчлэн одоо мөрдөж буй Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/93 дугаар тушаалаар баталсан журмын дагуу багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах үйл ажиллагааг цаашид нэг журмаар зохицуулах боломжгүй байгаа тул “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшид мэргэжлийн зэрэг олгох, хасах журам”-ыг шинэчлэн боловсруулах зайлшгүй шаардлагатай болсон.

Иймд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/75 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг нь зөвлөгөөний санал, холбогдох хууль дүрэмд нийцүүлэн журмын төслийг шинэчлэн боловсруулсан.

Журамд мэргэжлийн зэрэг олгох үйл явцыг багшлах үйл ажиллагаа, сургалтын чанар, үр дүнтэй шууд хамааралтай байхуйцаар зохион байгуулж, шалгуур үзүүлэлтийг багшийн зөвхөн хувийн мэдлэг, ур чадварыг үнэлэхээр хязгаарлахгүй, мэдлэг, ур чадвараа хэрхэн үр дүн болгож буйг тодорхойлж, ажил мэргэжлээрээ өсөн дэвших нөхцлийг бүрдүүлсэн.

Багшийн мэргэжлийн зэргийн хүчинтэй байх хугацааг 5 жил байхаар өөрчилсөн. Мөн “Багшийн хөгжил, нийгмийн асуудал” зөвлөгөөний үеэр мэргэжлийн зэрэгтэй багш нарыг удирдаж буй удирдах албан тушаалтан мэргэжлийн зэрэггүй байгаа нь захирах, захирагдах ёс зүйд зөрчилдөөн үүсгэж байгаа гэсний болон, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн дагуу захиралд мэргэжлийн зэрэг олгохоор тусгасан.

“Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшид мэргэжлийн зэрэг олгох, хасах” журмын төсөл нь 7 бүлэг, 40 зүйл, 23 заалттай. Мэргэжлийн зэрэг олгох шалгуурыг сургалтын чанар, мэргэжил арга зүйн ур чадвар, суралцагч, багш хамт олон, эцэг эх асран хамгаалагчийн сэтгэл ханамж, өөрийгөө хөгжүүлсэн байдал, судалгаа шинжилгээ, инноваци, ажил мэргэжил, ур чадварын уралдаан, олимпиад, бүтээлийн үзэсгэлэнд оролцсон байдлаар тодорхойлсон.

Журмын ерөнхий шалгуурын багцад сурлагын чанар, мэргэжил арга зүйн ур чадвар, тухайн багшийн талаарх сэтгэл ханамж, багшийн өөрийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдлыг үнэлж дүгнэхээр тусгасан. Журамд тухайн багшийн суралцагчийг хөгжүүлж буй бодит үр дүн, чанарыг илэрхийлэх боломжгүй байсан “сургалтын амжилт, чанар” гэсэн шалгуурыг “сургалтын чанар” болгон өөрчилсөн нь салбарын онцлог, суралцагчийн мэргэжлийн ур чадвар, чанарыг илүү бодитой тодорхойлох боломжтой гэж үзсэн.

Журмын төсөлд “мэргэжил арга зүйн ур чадвар” шалгуурыг бий болгосон нь багш заах арга зүй, мэргэжлийн ур чадвар, сайн туршлагаа бусдад түгээн дэлгэрүүлснээр салбарын болон олон улсын чиг хандлага, өөрчлөлтөд өөрийгөө бэлтгэх, тасралтгүй суралцах, мэргэжлийн хувьд өсөж дэвших, манлайлалыг дэмжих боломжийг бүрдүүлсэн.

Мөн багшийн бүтээлч үйл ажиллагаа, судалгаа шинжилгээг хөгжүүлж, сургалт үйлдвэрлэлд ашигтай шинэ санаа, бүтээл, инноваци бий болгох, бүтээлч ажлаа зөв үнэлүүлэх, хөгжих нөхцлийг бүрдүүлсэн.

Багшийн мэргэжлийн зэрэг нь багш ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийн хүрээнд үр дүнтэй ажиллаж, тодорхой амжилт гаргасныг харуулсан баталгаа болно. Өөрөөр хэлбэл, мэргэжлийн зэрэг нь сургалтын чанарыг нэмэгдүүлэх, багшийг чанаржуулах хөшүүрэг юм.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

## МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН БАГШИД МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ, ХАСАХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, сургалт арга зүйн байгууллага (цаашид “сургалтын байгууллага” гэх)-ын багшид мэргэжлийн зэрэг олгох, хасахтай холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Мэргэжлийн зэрэг нь багш, их, дээд сургуулийг багш мэргэжлээр төгссөн, сургалтын байгууллагад ажиллаж байгаа сургалтын менежер, арга зүйч, захирал (цаашид “багш” гэх)-д хамаарна.
- 1.3. Мэргэжлийн зэрэг нь сургалтын байгууллагын багш, ажилтны албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлж, үр дүнд хүрсний баталгаа, мэргэжил, ур чадварын өсөлт, хөгжлийг дэмжихэд чиглэнэ.
- 1.4. Мэргэжлийн зэрэг олгох, хасах үйл ажиллагаа нь үр дүнд суурилсан, ил тод, нээлттэй, шударга, хамтын оролцоог хангасан, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.
- 1.5. “Мэргэжлийн зэрэг олгох, хасах” гэдэгт мэргэжлийн зэргийг шинээр олгох, бататгах, бууруулах, хасах үйл ажиллагааг ойлгоно.
- 1.6. “Мэргэжлийн зэрэг бататгах” гэдэгт эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр өмнө олгосон зэргийн шалгуурыг давтан хангаж буйг баталгаажуулахыг ойлгоно.
- 1.7. Багшид мэргэжлийн зэргийг шатлал алгасуулан олгохгүй.
- 1.8. Энэ журмын 2.1-д заасан шалгуурыг бүрэн хангасан багшид Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 9.2-т заасныг үндэслэн хугацаанаас нь өмнө мэргэжлийн зэрэг олгож болно.
- 1.9. “Заах аргач багш”, “Тэргүүлэх багш”, “Зөвлөх багш” мэргэжлийн зэргийг Мэргэжлийн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тус олгоно.

### ХОЁР. МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ШАЛГУУР

- 2.1. Мэргэжлийн зэрэг олгоход дараах шалгуурыг баримтална:
  - 2.1.1. Сургалтын чанар;
  - 2.1.2. Мэргэжил, арга зүйн ур чадвар;
  - 2.1.3. Суралцагч, багш, хамт олон, эцэг эх асран хамгаалагчийн сэтгэл ханамж;
  - 2.1.4. Өөрийгөө хөгжүүлсэн байдал;
  - 2.1.5. Судалгаа шинжилгээ, шинэ бүтээл, инноваци нэвтрүүлсэн ажил;
  - 2.1.6. Ажил мэргэжил, ур чадварын уралдаан, олимпиад, бүтээлийн үзэсгэлэнд оролцсон байдал;

2.2. Багшийн албан тушаалын онцлогоос хамаарч мэргэжлийн зэрэгт тавих шалгуур дор дурдсан байдлаар ялгаатай байна.

ТӨСӨГ

2.2.1. Багшид мэргэжлийн зэрэг олгоход дараах шалгуурыг баримтална.

Шалгуур үзүүлэлт		оноо	Заах аргач	Тэргүүлэх	Зөвлөх
Ерөнхий шалгуур	Сурлагын чанар	20 оноо	Суралцагчдын сурлагын чанар хөндлөнгийн үнэлгээгээр сүүлийн 5 жилийн дунджаас 3-аас дээш хувиар өссөн байх	Суралцагчдын сурлагын чанар хөндлөнгийн үнэлгээгээр сүүлийн 5 жилийн дунджаар 3-аас дээш хувиар өссөн байх	Суралцагчдын сурлагын чанар хөндлөнгийн үнэлгээгээр сүүлийн 5 жилийн дунджаар 5-аас дээш хувиар өссөн байх
	Мэргэжил, арга зүйн ур чадвар	20 оноо	Сургалтын үйл ажиллагаандаа суралцагчдын болон мэргэжлийн онцлогт тохирсон сургалтын олон хувилбарт заах арга зүй, цахим хичээлийн хэрэглэгдэхүүн боловсруулах технологи эзэмшсэн байх	Суралцагчдын болон мэргэжлийн онцлогт тохирсон сургалтын олон хувилбарт заах арга зүй, цахим хичээлийн хэрэглэгдэхүүн боловсруулах технологийг эзэмшин бүс, орон нутгийн түвшинд түгээн дэлгэрүүлэх, зөвлөн туслах, сургалт 2-3 удаа зохион байгуулсан байх	Сургалтын олон хувилбарт заах арга зүй, цахим хичээлийн хэрэглэгдэхүүн боловсруулах технологийг туршлага болгож, үндэсний түвшинд түгээн дэлгэрүүлэх, зөвлөн туслах, сургалт 2-3 удаа зохион байгуулж, мэргэжил арга зүйн чиглэлээр гарын авлага, зөвлөмж боловсруулсан байх
		15 оноо	Сургалтын хөтөлбөр ашиглаж, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх арга зүйг эзэмшсэн байх	Сургалтын хөтөлбөр боловсруулах багт ажилласан, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, үр дүнг сайжруулах бүтээлч арга зүй, шинэ технологийг нэвтрүүлсэн байх	Сургалтын хөтөлбөр боловсруулах багт ажилласан, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, үр дүнг сайжруулах бүтээлч арга зүй, шинэ технологи, туршлагыг бүс, үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлсэн байх

	Суралцагч, багш, хамт олон, эцэг эх асран хамгаалагчийн сэтгэл ханамж	10 оноо	<ul style="list-style-type: none"> <li>Мэргэжлийн ур чадвар, ёс зүй, хариуцлагатай холбоотой үндэслэл, нотолгоотой гомдол суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, хамт олноос гараагүй байх</li> <li>Ажлын байранд эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж, осол гэмтэл, зөрчил гаргаагүй байх</li> </ul>		
	Өөрийгөө хөгжүүлсэн байдал	10 оноо	Өөрийн үнэлгээнд тулгуурласан хувийн хөгжлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт		
<b>Тусгай шалгуур</b>	Судалгаа шинжилгээ, шинэ бүтээл, инноваци нэвтрүүлсэн байдал	15 оноо	Судалгаа, эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд өөрөө болон шавь нь илтгэл амжилттай хэлэлцүүлсэн байх	Бүс, орон нутгийн хэмжээнд судалгаа, эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд өөрөө болон шавь нь илтгэл амжилттай хэлэлцүүлсэн байх Сургалт, үйлдвэрлэлд ашиглах боломжтой шинэ бүтээлийн санаа, технологи, инновацийг дэвшүүлсэн байх	Үндэсний болон олон улсын хэмжээнд судалгаа, эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд өөрөө болон шавь нь илтгэл амжилттай хэлэлцүүлсэн байх Сургалт, үйлдвэрлэлд ашиглах боломжтой шинэ бүтээлийн санаа, технологи, инновацийг туршсан байх
	Ажил мэргэжил, ур чадварын уралдаан, олимпиад, бүтээлийн үзэсгэлэнд оролцсон байдал	10 оноо	Ажил мэргэжил, ур чадварын уралдаан тэмцээн, бүтээлийн үзэсгэлэн, олимпиадад өөрөө болон шавь нар нь амжилттай оролцож шагналт байранд шалгарсан байх	Бүс, орон нутгийн хэмжээнд ажил мэргэжил, ур чадварын уралдаан тэмцээн, бүтээлийн үзэсгэлэн олимпиадад өөрөө болон шавь нар нь амжилттай оролцож шагналт байранд шалгарсан байх	Олон улс, үндэсний хэмжээнд ажил мэргэжил, ур чадварын уралдаан тэмцээн, бүтээлийн үзэсгэлэн, олимпиадад өөрөө болон шавь нар нь амжилттай оролцож шагналт байранд шалгарсан байх
<b>Нийт оноо</b>		<b>100</b>			

2.2.2. Сургалтын менежер/арга зүйч багшид мэргэжлийн зэрэг олгоход дараах шалгуурыг баримтална.

Шалгуур үзүүлэлт		Оноо	Заах аргач	Тэргүүлэх	Зөвлөх
Ерөнхий шалгуур	Сурлагын чанар	20 оноо		Сургууль, хариуцсан хэсгийн суралцагчдын сурлагын чанар хөндлөнгийн үнэлгээгээр сүүлийн 5 жилийн дунджаар 3-аас дээш хувиар өссөн байх	Сургууль, хариуцсан хэсгийн суралцагчдын сурлагын чанар хөндлөнгийн үнэлгээгээр сүүлийн 5 жилийн дунджаар 5-аас дээш хувиар өссөн байх
	Мэргэжил, арга зүйн ур чадвар	15 оноо	Сургалтын менежер/арга зүйчийн албан тушаалд ажиллах багш заах аргач ба түүнээс дээш мэргэжлийн зэрэгтэй байх	Ажлын байранд багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилт 80 хувьд хүрсэн байх	Ажлын байранд багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилт 90 хувьд хүрсэн байх
		8 оноо		Хариуцсан хэсгийн нийт багшийн 80 -аас доошгүй хувьд мэргэжил арга зүйн чадварыг дээшлүүлэхэд зөвлөн тусалж, үр дүнд хүрсэн байх	Хариуцсан хэсгийн нийт багшийн 90 -аас доошгүй хувьд мэргэжил арга зүйн чадварыг дээшлүүлэхэд зөвлөн тусалж, үр дүнд хүрсэн байх
		8 оноо		Бүс, орон нутгийн багш нарт 5-аас доошгүй удаа сургалт, зөвлөн туслах, туршлага солилцох үйл ажиллагаа зохион байгуулсан байх	Үндэсний хэмжээнд багш нарт 8-аас доошгүй удаа сургалт, зөвлөн туслах, туршлага солилцох үйл ажиллагаа зохион байгуулсан байх
		8 оноо		Дагалдуулан сургасан 5-аас дээш багшийн ажлын амжилт ахисан байх	Дагалдуулан сургасан 8-аас дээш багшийн ажлын амжилт ахисан байх

		9 оноо	Хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, шинэ технологийг сургалтад нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, сайн туршлагыг бүсийн, орон нутгийн хэмжээнд 3-аас доошгүй удаа түгээн дэлгэрүүлсэн байх	Хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, шинэ технологийг сургалтад нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, сайн туршлагыг үндэсний хэмжээнд 5-аас доошгүй удаа түгээн дэлгэрүүлж, мэргэжил арга зүйн чиглэлээр гарын авлага, зөвлөмж боловсруулсан байх
	Суралцагч, багш, хамт олон, эцэг эх асран хамгаалагчийн сэтгэл ханамж	10 оноо	<ul style="list-style-type: none"> <li>• Ажлын чанар, мэргэжлийн ур чадвар, ёс зүй, хариуцлагатай холбоотой үндэслэл, нотолгоотой гомдол багш, эцэг, эх, асран хамгаалагчаас гараагүй байх</li> <li>• Сургуулийн нийт багш нарын сэтгэл ханамжийн үнэлгээ 90 - ээс дээш хувьтай үнэлэгдсэн байх</li> <li>• Ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй байх</li> </ul>	
	Өөрийгөө хөгжүүлэх	10 оноо	Өөрийн үнэлгээнд тулгуурласан хувийн хөгжлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт	
<b>Тусгай шалгуур</b>	Судалгаа, инноваци, шинэ технологи	10 оноо	Сургалтын чанар, стандарт, мэргэжлийн ур чадвар, багш, суралцагчийн хөгжлийн талаар бие даасан судалгааны үр дүнг 2 -оос доошгүй удаа бүс, орон нутгийн хэмжээнд хэлэлцүүлсэн байх	Сургалтын чанар, стандарт, мэргэжлийн ур чадвар, багш, суралцагчийн хөгжлийн талаар бие даасан судалгааны үр дүнг 3-аас доошгүй удаа үндэсний хэмжээнд хэлэлцүүлж, зөвлөмж боловсруулсан байх
			Сургалт үйлдвэрлэлд ашигтай шинэ технологи, инноваци нэвтрүүлэх ажлыг дэмжсэн, санаачилсан, удирдсан байх	
Нийт оноо 100				

2.2.3. Сургалтын байгууллагын захирал багшид мэргэжлийн зэрэг олгоход дараах шалгуурыг баримтална.

Шалгуур үзүүлэлт		Оноо	Заах аргач	Тэргүүлэх	Зөвлөх
Ерөнхий шалгуур	Сурлагын чанар	20 оноо		Суралцагчдын сурлагын чанар хөндлөнгийн үнэлгээгээр сүүлийн 5 жилийн дунджаар 3-аас дээш хувиар өссөн байх	Суралцагчдын сурлагын чанар хөндлөнгийн үнэлгээгээр сүүлийн 5 жилийн дунджаар 5-аас дээш хувиар өссөн байх
	Мэргэжил, арга зүйн ур чадвар	10 оноо		Сургуулийн үйл ажиллагааны үр дүнд дүн шинжилгээ хийж, сургууль хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, үр дүнг жил бүр тооцон ажилласан байх	
		10 оноо	Сургалтын байгууллагын захирлын албан тушаалд ажиллах багш заах аргач ба түүнээс дээш мэргэжлийн зэрэгтэй байна.	Бүс, орон нутгийн хэмжээнд зөвлөн туслах, туршлага солилцох үйл ажиллагааг 2-оос доошгүй удаа зохион байгуулсан байх	Үндэсний хэмжээнд сургуульд зөвлөн туслах, туршлага солилцох үйл ажиллагааг 5-аас доошгүй удаа зохион байгуулсан байх
		15 оноо		Багш, ажилтны нийгмийн асуудлыг шийдэх чиглэлээр санал, санаачилга гарган ажилласан байх	
		10 оноо		Сургалтын байгууллагын орчинд багш, ажилтан, суралцагч эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулсан арга хэмжээ, үр дүн	
	Суралцагч, багш, хамт олон, эцэг эх асран хамгаалагчийн сэтгэл ханамж	10 оноо		<ul style="list-style-type: none"> <li>Ажлын чанар, мэргэжлийн ур чадвар, ёс зүй, хариуцлагатай холбоотой үндэслэл, нотолгоотой гомдол багш, эцэг, эх, асран хамгаалагчаас гараагүй байх</li> <li>Сургалтын байгууллагын хамт олон, эцэг, эх, асран хамгаалагч, олон нийтийн сэтгэл ханамжийн үнэлгээ 90-ээс дээш хувьтай байх</li> <li>Ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй</li> </ul>	

			байх
	Өөрийгөө хөгжүүлэх	10 оноо	Өөрийгөө хөгжүүлэх хувийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт
<b>Тусгай шалгуур</b>	Судалгаа, инноваци, шинэ технологи	15 оноо	Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын хөгжлийг дэмжсэн үндэсний хэмжээний хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэхэд тодорхой үүрэг хүлээн тогтвортой ажилласан (Green TVET-ыг хөгжүүлэх, МБС-ын жендерийн бодлого төлөвлөлт, эрэгтэй, эмэгтэй суралцагчдад ээлтэй орчин бүрдүүлэх бодлого төлөвлөлт, дижитал суурьтай сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, ашиглах чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн)
Нийт оноо		100	

## ГУРАВ. МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ

- 3.1. Мэргэжлийн зэрэг олгох, сунгуулах, ахиулах хүсэлтийг мэргэжлийн зэрэг хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнөх оны 3 дугаар сарын 01-ний дотор сургалтын байгууллагад гаргана.
- 3.2. Мэргэжлийн зэрэг олгох, сунгуулах, ахиулах хүсэлт гаргагч дараах материалыг бүрдүүлнэ:
  - 3.2.1. Мэргэжлийн зэрэг олгох сунгуулах, ахиулахыг хүссэн хувийн өргөдөл;
  - 3.2.2. Мэргэжлийн зэрэгтэй тохиолдолд үнэмлэхийн хуулбар;
  - 3.2.3. Энэ журмын 2.2.1, 2.2.2, 2.2.3-т тус тус заасан шалгуур хангасныг нотлох материал;
- 3.3. Багшид мэргэжлийн зэрэг олгох, сунгуулах, ахиулах ажлын хэсгийг сургуулийн захирлын тушаалаар томилон ажиллуулна.
  - 3.3.1. Сургалтын байгууллага нь мэргэжлийн зэрэг олгох (сунгуулах, ахиулах)-ыг хүссэн багшийн материалд үнэлгээ өгч багш нарын зөвлөлийн хуралд танилцуулна.
  - 3.3.2. Сургалтын байгууллагын захирал нь ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн багшид “Заах аргач багш” мэргэжлийн зэрэг олгосон тухай захирлын тушаалыг нээлттэй мэдээлж, шийдвэрийн хуулбарыг тухайн багшид өгнө.
  - 3.3.3. Сургалтын байгууллага нь “Тэргүүлэх багш”, “Зөвлөх багш” мэргэжлийн зэргийн шалгуурыг хангасан гэж үзсэн ажлын хэсгийн дүгнэлтийг нотлох материалын хамт жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор Мэргэжлийн боловсрол сургалтын Үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвд хүргүүлнэ.
- 3.4. “Тэргүүлэх багш”, “Зөвлөх багш” мэргэжлийн зэргийн шалгуурыг хангасан багшийн материалыг магадлан шалгах дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг Мэргэжлийн боловсрол сургалтын Үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн даргын тушаалаар томилон ажиллуулна.
  - 3.4.1. Мэргэжлийн зэргийн шалгуур үзүүлэлтийн 80-аас дээш оноо авсан тохиолдолд багшийг мэргэжлийн зэргийн шалгуур үзүүлэлтийг хангасанд тооцно.
  - 3.4.2. Ажлын хэсэг шаардлагатай тохиолдолд тухайн мэргэжлийн зэрэгт тавих шалгуурыг нэр дэвшигч хангаж буй эсэхийг ажлын байранд нь очиж магадлан шалгаж болно.
  - 3.4.3. Мэргэжлийн боловсрол сургалтын Үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв нь “Тэргүүлэх багш”, “Зөвлөх багш” мэргэжлийн зэргийн шалгуурыг хангасан багш нарын нотлох материал, ажлын хэсгийн дүгнэлтийг жил бүрийн 5 дугаар сарын 01-ний дотор Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- 3.5. Мэргэжлийн боловсрол сургалтын Үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн дүгнэлтийг үндэслэн “Тэргүүлэх багш”, “Зөвлөх багш” мэргэжлийн зэрэг олгох, эсэх шийдвэрийг Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана.

3.6. “Тэргүүлэх багш”, “Зөвлөх багш” мэргэжлийн зэргийн үнэмлэхийг жил бүрийн 6 дугаар сард багтаан олгоно.

### **ДӨРӨВ. МЭРГЭЖЛИЙН ЗЭРГИЙН НЭМЭГДЭЛ**

- 4.1. Мэргэжлийн зэрэг шинээр олгосон багшид нэмэгдлийг дараа оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож олгоно.
- 4.2. Сургалтын байгууллага нь мэргэжлийн зэргийн нэмэгдэлд шаардагдах зардлыг тооцож, жил бүрийн төсөвт тусгана.

### **ТАВ. БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ХҮЧИНТЭЙ БАЙХ ХУГАЦАА, БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ЗЭРГИЙГ ХАСАХ**

- 5.1. Мэргэжлийн зэргийн хүчинтэй хугацаа 5 жил байна.
- 5.2. Багшийн мэргэжлийн зэрэг нь Монгол улсын нутаг дэвсгэрт нэгэн адил хүчинтэй үйлчилнэ.
- 5.3. Багш нь сургалтын менежер, арга зүйч, захирал албан тушаалд дэвшин ажиллах тохиолдолд тэдний мэргэжлийн зэрэг энэ журмын 5.1-д заасан хугацаанд хүчинтэй байна.
- 5.4. “Заах аргач багш” мэргэжлийн зэргийг нэг удаа бататгаж болох бөгөөд зэргээ ахиулаагүй тохиолдолд “Заах аргач багш” зэрэг нь хүчингүй болно.
- 5.5. “Зөвлөх багш” мэргэжлийн зэргийг хоёр удаа бататгасны дараа энэ журмын 5.7 -д заасан зөрчил гаргаагүй тохиолдолд зэргийг дахин бататгахгүйгээр хүчинтэй байна.
- 5.6. Мэргэжлийн зэргийг ахиулахаар хүсэлт гаргаж, тухайн зэргийн шалгуурыг хангаагүй тохиолдолд өмнөх зэргийн шалгуураар нэг удаа үнэлж болно.
- 5.7. Мэргэжлийн зэрэг олгосон байгууллага нь дараах тохиолдолд багшийн мэргэжлийн зэргийг бууруулах эсхүл хасна.
  - 5.7.1. Энэхүү журмын 1.2-д зааснаас өөр албан тушаалд ажиллаж байгаа тохиолдолд;
  - 5.7.2. Жилийн ажлын үнэлгээ нь 3 удаа 70-аас доош хувьтай үнэлэгдсэн;
  - 5.7.3. Багш, удирдах ажилтны ёс зүйн дүрэмд заасан хэм хэмжээг зөрчсөн;
  - 5.7.4. Тухайн мэргэжлийн зэргийн шалгуурыг хангахгүй болсон;
  - 5.7.5. Суралцагчийн эрхэд халдсан;
- 5.8. Хоёр ба түүнээс дээш шатлалын эмнэлэгийн дүгнэлтээр хүндээр өвчилсөн, 3-аас дээш сарын хугацаагаар гадаадад томилолтоор ажилласны улмаас мэргэжлийн зэргээ хугацаанд нь бататгаж, эсвэл ахиулж чадаагүй бол өмнөх зэргийг нэг жил хадгална. Бусад тохиолдолд мэргэжлийн зэргийн хүчинтэй хугацаа хэтэрсэн бол мэргэжлийн зэргийг хасна.
- 5.9. Хөдөлмөрийн тухай хуулийн 106.1-д заасны дагуу амаржсаны болон хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацааг мэргэжлийн зэргийн хүчинтэй байх хугацаанаас хасаж тооцно.

- 5.10. Мэргэжлийн зэрэг нь хүчингүй болсон багш зэргээ сэргээх хүсэлтийг 1 жилийн дараа гаргаж болно.
- 5.11. Дэлхийн ур чадварын уралдаанд онцгой амжилт гаргасан тохиолдолд энэ журмын 1.8-ыг үндэслэн хугацаа харгалзахгүй зэрэг олгож болно.
- 5.12. Багш нь боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын газарт албан тушаал дэвшин ажиллахад тухайн багшийн мэргэжлийн зэрэг хэвээр хадгалагдана.

## **ЗУРГАА. БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ЗЭРГИЙН ҮНЭМЛЭХНИЙ ЗАГВАР**

- 6.1. Багшид "Заах аргач багш", "Тэргүүлэх багш", "Зөвлөх багш" мэргэжлийн зэргийг гэрчлэх үнэмлэх олгоно.
- 6.2. Багшийн мэргэжлийн зэргийн үнэмлэхийг ижил хэмжээ, дизайн бүхий загвараар хийнэ. Үнэмлэхийн бичвэр, гадна буюу дотор өнгө нь мэргэжлийн зэрэг бүрээр ялгаатай байна. "Заах аргач багш" мэргэжлийн зэргийн үнэмлэх ногоон, "Тэргүүлэх багш" мэргэжлийн зэргийн үнэмлэх цэнхэр, "Зөвлөх багш" мэргэжлийн зэргийн үнэмлэх улаан өнгөтэй байна.
- 6.3. Зэргийн үнэмлэхний нүүрэн талд "Соёмбо" тэмдэг зурж, БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ЗЭРГИЙН ҮНЭМЛЭХ гэж алтан боронзоор үндэсний монгол бичгээр бичнэ.
- 6.4. Зэргийн үнэмлэхний дотор талын бичвэрийг Хавсралт 1-ийн дагуу бичнэ.


## **ДОЛОО. БУСАД**

- 7.1. Сургалтын байгууллага мэргэжлийн зэрэг олгосон багшийн мэдээллийг маягт (Хавсралт 2) -ын дагуу бүртгэж, мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын мэдээллийн системд бүртгэнэ.
- 7.2. Энэхүү журмын 3.2-т заасан материал, багшид мэргэжлийн зэрэг олгох санал, дүгнэлт, шийдвэрийг сургалтын байгууллага, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ мэдээлэл, арга зүйн төвд тус тус архивын нэгж үүсгэн архивт шилжүүлнэ.
- 7.3. Үндэсний үнэт цаас ХХК-д үнэмлэх хэвлүүлэхтэй холбогдон гарах зардлыг багш хариуцна.
- 7.4. Мэргэжлийн зэрэг олгох, хасах үйл ажиллагаанд 1.4-д заасан зарчмыг зөрчсөн, шалгуур хангаагүй багшид мэргэжлийн зэрэг олгосон багшид мэргэжлийн зэрэг олгосон шийдвэрийн баталгаажилт хууль бус гэж үзсэн тохиолдолд холбогдох байгууллагад гомдол гаргаж болно.
- 7.5. Багшийн мэргэжлийн зэргийн үнэмлэхийг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд эрх бүхий байгууллага хүсэлтийг үндэслэн нөхөн олгоно.

## Хавсралт 1

Үнэмлэхний дугаар: .....

Бүртгэлийн дугаар: .....



.....  
сургуулийн захирлын  
20... оны ..... -р сарын ..... -ны өдрийн ..... тушаалыг  
үндэслэн “ЗААХ АРГАЧ БАГШ” мэргэжлийн  
зэрэг олгов.

ЗАХИРАЛ / /

Овог: .....

Нэр: .....



Бүртгэлийн дугаар: .....

Захирлын 20... оны ..... -р сарын ..... -ны өдрийн .....  
тушаалыг үндэслэн 20... оны ..... -р сарын ..... -ны  
өдөр хүртэл сунгав.

ЗАХИРАЛ / /

Олгосон: 20..... оны ..... сарын ..... өдөр

Тайлбар: Багшийн мэргэжлийн зэргийн үнэмлэхний дугаарын кодлолт

**МБ-3-200103**

МБ	Мэргэжлийн боловсрол
3	“ЗААХ АРГАЧ БАГШ” мэргэжлийн зэргийн код
20	Багшийн мэргэжлийн зэргийн үнэмлэх олгосон оны сүүлийн хоёр тоо
01	Сургуулийн захирлын тушаалын дугаар
03	Багшийн нэрийн код буюу захирлын тушаал дахь нэрийн дугаар

Үнэмлэхний дугаар: .....

Бүртгэлийн дугаар: .....



“Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшид мэргэжлийн зэрэг олгох тухай”  
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын  
20... оны ..... -р сарын ..... -ны өдрийн ..... тушаалыг  
үндэслэн “ТЭРГҮҮЛЭХ БАГШ” мэргэжлийн  
зэрэг олгов.

САЙД / /

Овог: .....

Нэр: .....



26129248-3377-11ca-8976-75ba-c3889627

Бүртгэлийн дугаар: .....

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын  
20... оны ..... -р сарын ..... -ны өдрийн ..... тушаалыг  
үндэслэн 20... оны ..... -р сарын ..... -ны  
өдөр хүртэл сунгав.

САЙД / /

Олгосон: 20..... оны ..... сарын ..... өдөр

Тайлбар: Багшийн мэргэжлийн зэргийн үнэмлэхний дугаарын кодлолт

**МБ-2-200103**


МБ	Мэргэжлийн боловсрол
2	“ТЭРГҮҮЛЭХ БАГШ” мэргэжлийн зэргийн код
20	Багшийн мэргэжлийн зэргийн үнэмлэх олгосон оны сүүлийн хоёр тоо
01	Сайдын тушаалын дугаар
03	Багшийн нэрийн код буюу Сайдын тушаал дахь нэрийн дугаар

Үнэмлэхний дугаар: .....

Бүртгэлийн дугаар: .....



ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



“Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшид мэргэжлийн зэрэг олгох тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 20... оны ..... -р сарын ..... -ны өдрийн ..... тушаалыг үндэслэн “ЗӨВЛӨХ БАГШ” мэргэжлийн зэрэг олгов.

САЙД / /

Овог: .....

Нэр: .....

Бүртгэлийн дугаар: .....

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 20... оны ..... -р сарын ..... -ны өдрийн ..... тушаалыг үндэслэн 20... оны ..... -р сарын ..... -ны өдөр хүртэл сунгав.

САЙД / /



Олгосон: 20... оны ..... сарын ..... өдөр

Тайлбар: Багшийн мэргэжлийн зэргийн үнэмлэхний дугаарын кодлолт

**МБ-2-200103**

МБ	Мэргэжлийн боловсрол
1	“ЗӨВЛӨХ БАГШ” мэргэжлийн зэргийн код
20	Багшийн мэргэжлийн зэргийн үнэмлэх олгосон оны сүүлийн хоёр тоо
01	Сайдын тушаалын дугаар
03	Багшийн нэрийн код буюу Сайдын тушаал дахь нэрийн дугаар

## Хавсралт 2

### Мэргэжлийн боловсролын сургалтын байгуулагын багш, ажилтанд мэргэжлийн зэрэг олгосон мэдээлэл

№	Овог нэр	Хүйс	Нас	Мэргэжил	Боловсролын зэрэг	Эрхэлж байгаа албан тушаал	Ажилласан жил	Олгосон он сар өдөр			Мэргэжлийн зэрэг сунгасан он сар өдөр	Мэргэжлийн зэрэг бууруулсан эсхүл хассан он сар өдөр	Мэргэжлийн зэрэг олгосон бүртгэлийн дугаар	Тайлбар
								Заах аргач	Тэргүүлэх	Зөвлөх				

Мэдээллийг нэгтгэсэн .....  
 / гарын үсэг, албан тушаал, тамга, тэмдэг /

.....  
 / овог, нэр /

---000---